Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГО, ТОЛИЛУУЛГАД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТҮҮД

Богд сумын Засаг даргын 2023 санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1,847,533.9 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 461,845.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
МӨНГӨН ХӨРӨНГӨ	189,197.4	416,755.7	227,558.3
АВЛАГА	239,313.1	179,404.3	(59,908.8)
БАРАА МАТЕРИАЛ	60,607.7	69,511.7	8,903.9
НӨӨЦИЙН БАРАА	0.0	42,011.5	42,011.5
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,823,805.7	2,042,886.2	219,080.5
ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ	-927,235.6	-903,035.4	-24,200.2
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,385,688.4</b>	<b>1,847,533.9</b>	<b>461,845.5</b>
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	133.5	433.5	300.0
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,385,554.9	1,847,100.4	461,545.5
Засгийн газрын хувь оролцоо	1,385,554.9	1,847,100.4	461,545.5
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,385,688.4</b>	<b>1,847,533.9</b>	<b>461,845.5</b>

Эх сурвалж: Богд сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

#### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 189,197.4 мянга, эцсийн үлдэгдэл 416,755.7 мянган төгрөг болж 227,558.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	0	0	0	0
Банканд байгаа бэлэн мөнгө	189,197.4	416,755.7	227,558.3	100%
Орон нутгийн ерөнхий орлого	147,359.5	267,377.0	120,017.6	64%
Орон нутгийн хөгжлийн сан	15,595.9	48,881.0	33,285.1	12%
Хоршоо хөгжүүлэх сан	26,242.1	100,497.7	74,255.6	24%
Замд яваа мөнгөн хөрөнгө	0	0	0	0
Хадгаламж	0	0	0	0
<b>ДҮН</b>	<b>189,197.4</b>	<b>416,755.7</b>	<b>227,558.3</b>	<b>100%</b>

Эх сурвалж Богд сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 416,755.7 мянган төгрөгийн 64 хувь буюу орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл, 12 хувь нь ОНХС-ийн харилцах дансны үлдэгдэл, 24 хувь нь Хоршоо хөгжүүлэх сангийн үлдэгдэл байна.

Төрийн сангийн орон нутгийн ерөнхий орлогын данс дахь 120,017.6 мянган төгрөгийн 29,261.9 мянган төгрөг нь төсөвт байгууллагуудын оны эцэст буцааж төвлөрүүлсэн төвлөрүүлэх шилжүүлэг, 93,725.7 мянган төгрөг нь орон нутгийн орлого давснаас шалтгаалан төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл байна.

### 3.4.2 Авлага

Оны эхний 217,965.1 мянган төгрөгийн авлага 43,385.7 мянган төгрөгөөр нэмэгдэн оны эцэст 261,350.8 мянган төгрөгийн авлагатай гарчээ.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл / мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Бусад авлага	55,000.0	67,000.0	12,000.0	37%
Хувь хүмүүст олгосон зээл	184,313.1	112,404.3	-71,908.8	63%
<b>ДҮН</b>	<b>239,313.1</b>	<b>179,404.3</b>	<b>-59,908.8</b>	<b>100%</b>

Эх сурвалж: Богд сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт авлагын 63 хувийг Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон хувь хүмүүст олгосон зээл эзэлж байгаа ба авлагын 37 хувийг сумын ЗДТГ-ын авлага эзэлж байна.

Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 12,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий моторыг Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газраас ирүүлсэн чиглэлийг үндэслэн үндсэн хөрөнгөөс хасаж авлагаар бүртгэсэн байна.

### 3.4.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 60,607.7 мянга, эцсийн үлдэгдэл 111,523.2 мянган төгрөг болж, 50,915.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн сумын сургуулийн спорт заалны барилгын дээврийн засварын ажлын санхүүжилтийг аймгийн ОНХС-аас бүрэн аваагүй, ажил хийгдэж дуусаагүй тул нөөцийн барааны оны эцсийн үлдэгдэл 50,000.0 мянган төгрөг байгаа нь бараа материалын эцсийн үлдэгдлийн 15.8 хувийг эзэлж байна.

Хүснэгт 6. Бараа материалын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
1	ЗДТГ	56,047.1	65,989.4	9,942.23	59%
2	ИТХ	4,560.6	3,522.3	(1,038.30)	3%
3	ОНХС	-	42,011.5	42,011.50	38%
	<b>ДҮН</b>	<b>60,607.7</b>	<b>111,523.2</b>	<b>50,915.4</b>	<b>100%</b>

Эх сурвалж: Богд сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 137,429.3 мянган төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч, үйл ажиллагаанд 87,165.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 1,468.0 мянган төгрөгийн бараа материал акталсан байна.

### 3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 1,823,805.7 мянга, эцсийн үлдэгдэл 2,042,886.2 мянган төгрөг болж, 219,080.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Барилга байгууламж, орон сууц	546,303.1	807,546.8	261,243.8	40%
Тээврийн хэрэгсэл	232,864.8	184,880.0	-47,984.8	9%
Машин тоног төхөөрөмж	161,103.2	151,595.4	-9,507.8	7%
Тавилга эд хогшил	202,227.5	214,766.5	12,539.0	11%
Зам гүүрийн байгууламж	438,474.3	449,472.0	10,997.8	22%
Номын фонд	300.0	300.0	0.0	0%
Бусад үндсэн хөрөнгө	228,286.0	220,078.5	-8,207.5	11%
Программ хангамж	659.0	659.0	0.0	0%
Бусад биет бус хөрөнгө	13,588.0	13,588.0	0.0	1%
<b>Дүн</b>	<b>1,823,805.7</b>	<b>2,042,886.2</b>	<b>219,080.5</b>	

Эх сурвалж: Богд сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 27,217.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 334,310.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бусад байгууллагаас шилжүүлэн авсан бөгөөд сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөөс 130,447.6 мянган төгрөгийг хөрөнгө акталсан ба тооллогоор дутагдсан 12,000.0 мянган төгрөгийг үнэтэй моторыг данснаас хасаж авлагаар бүртгэсэн байна.

Хүснэгт 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
1	ЗДТГ	893,925.2	1,132,657.9	238,732.7	99%
2	ИТХ	2,645.0	7,192.9	4,547.9	1%
	<b>ДҮН</b>	<b>896,570.2</b>	<b>1,139,850.8</b>	<b>243,280.6</b>	<b>100%</b>

Эх сурвалж: Богд сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн үлдэгдэл 433.5 мянган төгрөг байна.

Хүснэгт 9. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Үүнээс:		
				Ажиллагсадтай холбоотой	Байгууллагад төлөх өглөг	Бараа үйлчилгээний зардлын өглөг
1	ЗДТГ	133.5	433.5	133.5	300.0	0.0
	<b>ДҮН</b>	<b>133.5</b>	<b>433.5</b>	<b>133.5</b>	<b>300.0</b>	<b>0.0</b>

Эх сурвалж: Богд сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

ЗДТГ-ын өмнөх оны 133.5 мянган төгрөгийг барагдуулаагүй тайланд онд 300.0 мянган төгрөгийг нэмж өглөг үүсгэсэн байна.

### 3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 1,385,554.9 мянга, эцсийн үлдэгдэл 1,847,100.4 мянган төгрөг болж, 461,545.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.4.7 Орлогын данс

Богд сумын ИТХ-ын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 8/08 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 361,860.0 мянга, татварын бус торгуулийн орлогыг 5,000.0 мянган, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 1,000.0 нийт 367,860.0 мянган төгрөгөөр баталсныг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 11/04 дугаар тогтоолоор цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг 17,570.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлснээр татварын орлогыг 379,430.0 мянган төгрөгөөр баталжээ.

Хүснэгт 11. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөгөөр/

Орлогын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Татварын орлого</b>	<b>379,430.0</b>	<b>582,623.1</b>	<b>203,193.1</b>	<b>154%</b>
<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	<b>231,770.0</b>	<b>262,246.3</b>	<b>30,476.3</b>	<b>113%</b>
1. Цалин хөлс, түүнтэй адилтгах орлого	193,270.0	207,225.7	13,955.7	107%
2. Үйл ажиллагааны орлого	10,000.0	19,363.1	9,363.1	194%
3. ҮХЭХ борлуулсны орлого	24,500.0	33,323.5	8,823.5	136%
4. Хадгаламжийн хүү	4,000.0	2,334.0	(1,666.0)	58%
<b>Өмчийн татвар</b>	<b>5,180.0</b>	<b>4,101.5</b>	<b>(1,078.6)</b>	<b>79%</b>
1. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	2,000.0	1,671.5	(328.56)	84%
2. Бууны албан татвар	3,180.0	2,430.0	(750.0)	76%
<b>Бусад татвар, төлбөр хураамж</b>	<b>142,480.0</b>	<b>316,275.3</b>	<b>173,795.3</b>	<b>222%</b>
1. Улсын тэмдэгтийн хураамж	10,000.0	20,998.7	10,998.6	210%
2. Газрын төлбөр	2,300.0	4,358.2	2,058.2	189%
3. Түгээмэл тархацтай АМНАТ	500.0	-	(500.0)	0%
4. Малын тоо толгойн албан татвар	75,500.0	76,325.0	825.0	101%
5. Хог хаягдлын үйлчилгээний хураамж	13,700.0	8,915.0	(4,785.0)	65%
6. Бусад татвар хураамж		1,248.4	1,248.4	
7. Ан амьтны нөөц ашигласны төлбөр	38,080.0	204,347.1	166,267.1	537%
8. Газрын дуудлага худалдааны орлого	2,400.0	83.0	(2,317.0)	3%
<b>Татварын бус орлого</b>	<b>57,134.7</b>	<b>100,874.5</b>	<b>43,739.8</b>	<b>177%</b>
1. Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,000.0	128.9	(871.1)	13%
2. Төсөвт байгууллагын өөрийн орлого	51,134.7	97,430.6	46,295.9	190%
2. Торгуулийн орлого	5,000.0	3,315.0	(1,685.0)	66%
<b>Орлогын нийт дүн</b>	<b>1,415,380.3</b>	<b>1,654,930.8</b>	<b>239,550.5</b>	<b>117%</b>

Эх сурвалж: Богд сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 154 хувь буюу 203,193.1 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн нь дараах орлогууд давж биелсэнтэй холбоотой байна. Үүнд:

- Тайлант онд төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэнтэй холбоотой цалин хөлс, түүнтэй адилтгах орлого 113.0 хувиар биелсэн;
- Боловсролын байгууллагын жилийн гүйцэтгэлийн үнэлгээгээр амжилттай үнэлэгдсэн багш нарт урамшуулал олгосон нь үйл ажиллагааны орлого давах шалтгаан болсон;
- Улсын тэмдэгтийн хураамжийн орлого 210 хувь буюу 10,998.6 мянган төгрөгөөр давж биелсэн.
- Ан амьтны нөөц ашигласны төлбөр 166,267.1 мянган төгрөгөөр давж биелсэн нь угалз болон шонхрын орлого орсонтой холбоотой байна

Харин иргэд үл хөдлөх хөрөнгийн албан татвар, хог хаягдлын үйлчилгээний хураамж, бууны төлбөр, газрын дуудлага худалдааны орлого, хүү торгуулийн орлогууд тасарсан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогыг сумын ИТХ батлахдаа сумын ЗДТГ өөрийн орлогоор 1,000.0 мянга, Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээл, хүүгийн эргэн төлөлтийн орлогоор 51,134.7 мянган төгрөг оруулахаас гүйцэтгэлээр сумын ЗДТГ орлогыг биелүүлээгүй байна.

Хүснэгт 12. Өөрийн орлого /мянган төгрөгөөр/

№	Сумын нэр	Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Өөрийн орлогын эх үүсвэрийн талаар тайлбар
1	Богд	ЗДТГ	1,000.0	128.9	(871.06)	13%	
2	Богд	Хоршоо хөгжүүлэх сан	51,134.7	97,430.6	46,295.9	191%	Зээлийн хүү, эргэн төлөлт
		<b>ДҮН</b>	<b>52,134.7</b>	<b>97,559.5</b>	<b>45,424.8</b>	<b>187%</b>	

Эх сурвалж: Богд сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.4.8 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71801, 71802, 71806, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 1,575,259.1 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,427,372.8 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 1,427,372.8 мянган төгрөгийг урсгал зардалд, 348,222.6 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Богд сумын Засаг даргын санхүүгийн тайланд нэгтгэгддэг 2 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, улсын төсвийн байгууллагын тогтмол зардлыг төлөвлөж хүргүүлсэн аймгийн СТСХ-т хүргүүлсэн ба сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 8/08 дугаар тогтоолоор сумын төсвийн нийт зардлыг 1,397,844.3 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн тогтоолоор анх 1,397,844.3 мянган төгрөгөөр баталсан, анхны төсөвт сумын ИТХ-ын хуралдааны 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 11/04 дугаар тогтоолоор төсөвт тодотгол хийж, 1,575,259.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт 12. Богд сумын Засаг даргын 2023 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэр /мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Анхны баталсан 2022.12.19 өдрийн 8/08 тогтоол	Сумын ИТХ-ын 2023.07.07-ны өдрийн 11/04 тогтоол	Дүнд эзлэх хувь
1	Татварын орлого	361,860.0	379,430.0	24%
2	Татварын бус орлого /торгуулийн орлого/	5,000.0	5,000.0	0%
3	Аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	582,980.6	690,442.4	44%
4	Сумын төсөвт аймгийн ОНХС-аас олгох шилжүүлэг	235,990.2	288,373.2	18%
5	Өөрийн орлого ЗДТГ	1,000.0	1,000.0	0%
6	Өөрийн орлого Хоршоо хөгжүүлэх сан	51,134.7	51,134.7	3%
7	Сумын төсвийн урьд оны үлдэгдэл	107,400.0	107,400.0	7%
8	Сумын ОНХС-ийн урьд оны үлдэгдэл	27,000.0	27,000.0	2%
9	Сумын хоршоо хөгжүүлэх сангийн урьд оны үлдэгдэл	25,478.8	25,478.8	2%
ДҮН		1,397,844.3	1,575,259.1	100

Эх сурвалж. Богд сумын ИТХ-ын хуралдааны тогтоол

Хүснэгт 13. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	ОНТ-г төвлөрүүлсэн
1	ЗДТГ	648,015.4	642,398.8	5,616.6	99.1%	4,745.5
2	ИТХ	122,832.7	101,403.7	21,429.0	82.6%	21,433.8
3	ЕБС	139,883.6	138,781.8	1,101.8	99.2%	1,101.8
4	Цэцэрлэг	41,891.9	41,404.9	487.0	98.8%	487.0
5	ЭМТ	69,087.0	67,741.9	1,345.1	98.1%	1,345.1
6	Соёлын төв	86,061.8	85,913.0	148.8	99.8%	148.8
7	ОНХС	390,873.2	348,222.6	42,650.6	89.1%	-
8	Хоршоо хөгжүүлэх сан	76,613.5	1,506.0	75,107.5	2.0%	-
ДҮН		1,575,259.1	1,427,372.8	147,886.3	90.6%	29,262.0

Эх сурвалж: Богд сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,427,372.8 мянган төгрөг буюу 90.6 хувьтай байгаа нь тогтмол зардлыг 3,192.3 мянган төгрөгөөр хэмнэсэн, ОНХС-аас хэрэгжүүлэн төсөл арга хэмжээг 42,650.6 мянган төгрөгөөр дутуу хэрэгжүүлсэн, Хоршоо хөгжүүлэн сангаас олгохоор төлөвлөсөн зээлийг олгоогүйгээс 75,107.6 мянган төгрөг хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Богд сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 55,265.8 мянга, ИТХ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 1,300.0 мянга, нийт 55,565.8 мянган төгрөгийг зарцуулан, ЗДТГ хэмнэлтийн 17.9 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Богд сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгохтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа гүйцэтгэж, үе шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Богд сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024.03.05-ны өдөр ирүүлсэн байна.

Богд сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд 1 дүгээр гарын үсгийг сумын Засаг дарга Л.Ганаа, 2 дугаар гарын үсгийг сумын санхүүгийн албаны дарга З.Нанжидмаа нар зурж хөрөнгийг захиран зарцуулсан байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны баталсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардал 1,516,791.3 төгрөгөөс 1 хувиар буюу 15,167.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 10,617.5 мянган төгрөгөөр тогтоосон, төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Богд сумын Засаг даргын харьяаны төсөвт байгууллагууд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласнаар дараах зардлуудыг хэмнэсэн байна.

Хүснэгт 14. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	334,190.2	330,997.9	3,192.3	99%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,848.8	28,539.6	1,309.2	96%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	137,500.0	57,577.3	79,922.7	42%

Эх сурвалж: Богд сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Завсрын аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалган 2023.08.01-нд ажилд орсон нягтлан бодогчоор хуулийн дагуу байршуулах бүх мэдээллийг нөхөн байршуулсан.

Богд сумын ОНХС илэн дансны нэгдсэн цахим хуудаст таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 60,723,100 (Жаран сая долоон зуун хорин гурван мянга нэг зуун) төгрөгийн зарлагын 2 гүйлгээг мэдээлээгүй, мөнгө, хөрөнгө зарцуулсан 20,250,000 (Хорин сая хоёр зуун тавин мянган) төгрөгийн 2 шийдвэр мэдээлээгүй зөрчил илэрч албан шаардлага хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

### 4.5 ЗАВСРЫН АУДИТЫН ҮР ДҮН, ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Богд сумын ЗДТГ, ИТХ-ын санхүүгийн тайланд ахлах аудитор М.Алтантуяа, тусгай сангуудын санхүүгийн тайланд аудитор Д.Цэдэвцэвээн нар завсрын аудитыг 2023 оны 09 дүгээр сард гүйцэтгэсэн.

Санхүүгийн тайлангийн завсрын аудитаар илэрсэн дээрх зөрчлийг төсөвт байгууллага, тусгай сангийн санхүүгийн тайланд залруулж арга хэмжээг авч ажилласан байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Богд сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн аудит хийж, хариуцлага тооцох албан шаардлага 3, зөвлөмж, албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Хариуцлага тооцох албан шаардлага	3	244,790.3	3	244,790.3	100%
Албан шаардлага	1	0	1	0	100%
Зөвлөмж	3	12,000.0	3	12,000.0	100%
Нийт дүн	7	256,790.3	7	256,790.3	100%

/мянган төгрөгөөр/

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

#### 4.7 Аудитын гол асуудал

Сумын Засаг даргын харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Богд сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн ЗДТГ нь “Хязгаарлалттай” санал дүгнэлт авч, ИТХ болон 2 тусгай сангийн санхүүгийн тайлан түүвэрт хамрагдаж, сумын Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Соёлын төвийн орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт, гүйцэтгэл төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэгдсэн байна.

Богд сумын Засаг даргын харьяаны байгууллагуудын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 110,903.7 мянган төгрөгийн 15 алдаа, зөрчил илэрснээс байгууллагуудын санхүүгийн тайланд 9,642.7 мянган төгрөгийн 7 алдааг залруулж, 1,826.0.0 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 84,573.1 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 14,861.9 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлжээ.

Хүснэгт 15. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн /мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Алдаа, зөрчлийн шийдвэрлэлт	Материаллаг эсэх	Зөрчлийн ангилал
А	1	2	3	4	5	6
1	Баянхонгор аймгийн Богд сумын ИТХ	Нягтлан бодох бүртгэлд 2023.07.25-ны 233.1 мянган төгрөгийн шатахууныг давхардуулан орлого авсан, 2023.06.16-ы өдрийн 460.9 мянган төгрөгийн шатахууныг шууд зардлаар бүртгэсэн.	694.1	Санхүүгийн тайланд залруулсан	Материаллаг бус	Санхүүгийн аудит

2	Богд сумын ЗДТГ	2023 оны 4 сард 124.2 мянган төгрөгийн цалин илүү олгосон. НДШ-ийн мэдээнд 550.0 мянган төгрөгөөр илүү мэдээлсэн	228.7	Санхүүгийн тайланд залруулсан	Материаллаг бус	Санхүүгийн аудит
3	Богд сумын ЗДТГ	Аж ахуйн материалын эхний үлдэгдэл 47,446.7 мянган төгрөг э тайланд бусад хангамжийн материалын эхний үлдэгдэл зөрүүтэй тайлагнасан.	-	Санхүүгийн тайланд залруулсан	Материаллаг бус	Санхүүгийн аудит
4	Богд сумын ОНХС	ОНХС-аас хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг сумын ИТХ-аар хэлэлцүүлж орлого аваагүй байна.	-	Санхүүгийн тайланд залруулсан	Материаллаг бус	Санхүүгийн аудит
5	Богд сумын Сум хөгжүүлэх сан	Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлагын дансны нэгтгэлээр зээлдэгч нарын 2023.10.01-ны байдлаарх үлдэгдлээр тулган шалгахад Зээлийн сарын мэдээний нэгтгэлээр нийт 12 зээлдэгчтэй холбоотой 122,634.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байхад санхүүгийн тайланд үлдэгдлийг 121,879.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.	755.4	Санхүүгийн тайланд залруулсан	Материаллаг бус	Санхүүгийн аудит
6	Богд сумын Сум хөгжүүлэх сан	ХХС-ийн зээлийн авлагын дансны нэгтгэлээр зээлдэгч нарын үлдэгдлийг 2023.10.01-ны байдлаар санхүүгийн тайлангаар байх үлдэгдлийг тулган шалгахад 5,040.6 мянган төгрөгийн 6 иргэний зээлийг зөрүүтэй бүртгэсэн.	5,040.6	Санхүүгийн тайланд залруулсан	Материаллаг бус	Санхүүгийн аудит
7	Богд сумын Сум хөгжүүлэх сан	Богд сумын ХХС-ийн 2023 оны 03 дугаар улирлын санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайланд зээлдэгч нараас төлсөн зээлийн хүүгийн орлого 2,923.9 мянган төгрөгийн санхүүгийн тайланд орлогоор хүлээн зөвшөөрөхгүй шууд авлагыг бууруулж тайлагнасан.	2,923.9	Санхүүгийн тайланд залруулсан	Материаллаг бус	Санхүүгийн аудит
<b>ЗАЛРУУЛСАН АЛДААНЫ ДҮН</b>			<b>9,642.7</b>			
1	Богд сумын ЗДТГ	Засаг даргын нөөц хөрөнгөөс 2 удаагийн захирамжаар Эмэгтэйчүүдийн зөвлөлд 2,800.0 мянган төгрөг, "Гэр бүлийн андгай өргөх ёслол, Иргэний андгай өргөх ёслол" д 800.0 мянган төгрөг зарцуулсан	3,600.0	Албан шаардлага	Материаллаг	Санхүүгийн аудит
2	Богд сумын ЗДТГ	2023 оны 7 сард Анхбаярт ур чадварын нэмэгдэл шийдвэргүйгээр олгосон	303.3	Төлбөрийн акт	Материаллаг	Санхүүгийн аудит

3	Богд сумын ЗДТГ	Богд сумын Засаг даргын 2023.03.28-ны өдрийн А/37 дугаар "Шашин урлагийн цэнгүүн" -д 534.0 мянган төгрөг зарцуулсан	534.0	Төлбөрийн акт	Материаллаг	Санхүүгийн аудит
4	Богд сумын ЗДТГ	Богд сумын ЗДТГ-ын газар эзэмших гэрчилгээг нягтлан бодох бүртгэл, аймгийн ГХБХБГ-аас ирүүлсэн судалгаатай тулган шалгахад 26994 кв талбай бүхий 14 газар байгууллагын биет бус хөрөнгөд бүртгэлгүй байна.	-	Албан шаардлага	Материаллаг бус	Санхүүгийн аудит
5	Богд сумын ЗДТГ	2023 оны 1-8 сарын цалин тооцож олгоходоо Д.Ганболдын цалингаас ХХОАТ тооцож суутгаагүй	988.7	Төлбөрийн акт	Материаллаг	Санхүүгийн аудит
6	Богд сумын ЗДТГ	Завсрын аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалган 2023.08.01-нд ажилд орсон нягтлан бодогчоор хуулийн дагуу байршуулах бүх мэдээллийг нөхөн байршуулсан.	0	Зөвлөмж	Материаллаг бус	Нийцлийн аудит
7	Богд сумын Хоршоо хөгжүүлэх сан	ХХС-ийн зээлийн эргэн төлөлтийг 2020 оноос хөөн шалгаж түүвэрлэн тулгалт хийхэд аудитаар зээлдэгчийн үлдэгдэлтэй 7,322,154 төгрөгөөр 10 зээлдэгчийн зээлийг илүү, 7539815 төгрөгийн 56 зээлдэгчийг дутуу төлснөөр бичсэн ба зөрүү нь 172,661 төгрөг байна.	14,861.9	Зөвлөмж	Материаллаг бус	Санхүүгийн аудит
8	Богд сумын Орон нутаг хөгжлийн сан	Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 60,723,100 (Жаран сая долоон зуун хорин гурван мянга нэг зуун) төгрөгийн зарлагын 2 гүйлгээг мэдээлээгүй, мөнгө, хөрөнгө зарцуулсан 20,250,000 (Хорин сая хоёр зуун тавин мянган) төгрөгийн 2 шийдвэр мэдээлээгүй байна.	80,973.1	Албан шаардлага	Материаллаг бус	Нийцлийн аудит
ДҮН			101,261.0			
НИЙТ АЛДАА ЗӨРЧЛИЙН ДҮН			110,903.7			

Эх сурвалж: Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын зөрчлийн нэгтгэл

### Аудитын илрүүлэлт

Аудитаар зөрчил давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийг хүргүүлсэн.

Илрүүлэлт: Богд сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул байгаагаас нийт 110,903.7 мянган төгрөгийн 15 алдаа, зөрчил илэрснээс байгууллагуудын санхүүгийн тайланд 9,642.7 мянган төгрөгийн 7 алдааг залруулж, 1,826.0.0 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 84,573.1 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 14,861.9 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15.4.1.төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Харьяа төсөвт байгууллагуудын санхүү төсвийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, хариуцлагыг дээшлүүлэх, төсвийн сахилга батыг дээшлүүлж, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах.

Аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж биелэлтийг нотлох баримтын хамт 2023 оны 09 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл**

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал (мянган төгрөгөөр)**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Богд сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул байгаагаас 110,903.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэн	1	0					1	0
Дүн	1	0					1	0

---оОо---